

“УУЛ УУРХАЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖ, ХЭРЭГЖИЛТ”

СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР



СЕСМИМ
ТӨСӨЛ
МОНГОЛ УЛСЫН ОЛБОРЛОХ САЛБАРЫН
МЕНЕЖМЕНТИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

Сэдэв:

Ашигт малтмалын тухай хуулийн
давхардал, зөрчил, хийдлийн талаар авсан
арга хэмжээ

С.Цэцэг-Өлзий
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн
захиргааны удирдлагын газрын Хуулийн
хэлтсийн мэргэжилтэн

АГУУЛГА

- Ашигт малтмалын тухай хуулийн үзэл баримтлал, өөрчлөлт, чиг хандлага
- Ашигт малтмалын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдэл
 - Хуулийн давхардал, зөрчил, хийдлийн талаар
 - Чиг үүргийн давхардал, зөрчил, хийдлийн талаар
- Жишээ/ кейс/ факт
- Дүгнэлт
- Багаар ажиллах даалгавар, асуулт, хариулт



**Ашигт малтмалын тухай хуулийн үзэл
баримтлал, өөрчлөлт, чиг хандлага**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ӨӨРЧЛӨЛТ, ЧИГ ХАНДЛАГА

- Ашигт малтмалын тухай хуулийг анх 1997 онд баталж, 2006 онд шинэчлэн баталсан.
- Ашигт малтмалын тухай хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- Ашигт малтмалын тухай хууль 11 бүлэг 66 зүйлээс бүрдэж байна.
- Ашигт малтмалын тухай хууль батлагдсанаас хойш нийт 32 удаагийн 300 төрлийн нэмэлт, өөрчлөлт орсон байна. Үүнээс:
 - Хуулийн зүйл, хэсэг, заалтад нэмэлт оруулсан 49
 - Хуулийн зүйл, хэсэг, заалтад өөрчлөлт оруулсан 122
 - Хуульд шинээр зүйл, хэсэг, заалт нэмсэн 78
 - Хуулийн зүйл, хэсэг, заалтын агуулгыг өөрчлөн найруулсан 32
 - Хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгосон 19


Ашигт малтмалын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн талаар

- ХЗДХС-ын 2017 оны А/67 дугаар тушаалаар Уул уурхайн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хэсгийг байгуулж, холбогдох судалгааг 2 яамны албан хаагчид хамтран хийсэн байна.
- Энэ хүрээнд нийт эрдэс баялгийн салбарын 10 хуульд дүн шинжилгээ хийж нийт 267 давхардал, 150 зөрчил, 150 хийдэл тогтоосон байна.
- Үүнээс 104 нь Ашигт малтмалын тухай хуульд хамаарах бөгөөд тодруулбал, давхардсан 13, хийдэлтэй 58, зөрчилтэй 33 заалт тус тус байна.
- Иймд дээрх давхардал, зөрчил, хийдлийг шийдвэрлэх зорилгоор: Ашигт малтмалын тухай хуульд 7 зүйл бүхий нэмэлт, өөрчлөлт оруулж, түүнтэй холбоотойгоор 9 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулсан.

Хүснэгт 1. Давхардал, хийдэл, зөрчлийн судалгааны хүснэгт.

№	Хуулийн нэр	Давхардал	Хийдэл	Зөрчил
1	Ашигт малтмалын тухай	13	58	33
2	Газрын тосны тухай	1	19	16
3	Газрын тосны бүтээгдэхүүний тухай	7	12	4
4	Газрын хэвлийн тухай	27	21	25
5	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малмал хайх, ашиглахыг хориглох тухай	2	4	2
6	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	1	-	3
7	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай	212	11	17
8	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай	-	5	17
9	Цөмийн энергийн тухай	4	20	33
10	Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	-	-	-
Нийт		267	150	150

Дээр дурдсан судалгааны хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар



Ашигт малтмалын
тухай хуулийн
нэмэлт, өөрчлөлтийн
талаар

- Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм;
- Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм;
- Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй байдлын дүрэм;
- Ашигт малтмалын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам;
- Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах үлгэрчилсэн дүрэм;
- Тусгай зөвшөөрлийн бүртгэл хөтлөх журам;
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих тухай журам;
- Монгол орны нутаг дэвсгэрт геологи, геохими, гидрогеологийн зураглал, геофизик, геоэкологи, минерагени, металлогений судалгаа болон төрөл бүрийн ашигт малтмалын хайгуулын ажлыг гүйцэтгэх зааврууд.

Дагалдах бусад
хуулийн хувьд

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үүсээд буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх үүднээс 2014 онд батлагдсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болгож, уг хууль хүчингүй болсонтой холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсруулаад байна.

Чиг үүргийн давхардал, зөрчил, хийдлийн талаар

- Хяналт шалгалтын чиг үүргийн давхардал
- Эрх хэмжээний давхардал

Мэргэжлийн хяналтын байгууллага нь ашигт малтмалын үйл ажиллагаанд улсын хяналтын үүрэг гүйцэтгэдэг /§11.3/ харин геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих /§10.1.1, §10.1.8/ чиг үүрэгтэй.

Гэвч, Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн шаардлагаар улсын байцаагчийн эрхгүй бол хяналт хийх эрхгүй болж байгаа нь чиг үүргийн давхардал нь хууль хоорондын зөрчлийг үүсгэж байна

Нэмэлт: “42.4.Стратегийн ач холбогдол бүхий ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар энэ хуулийн 42.1-д заасан гэрээг аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулна. Стратегийн ач холбогдол бүхий ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тус гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулна.”

42 дугаар зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах

42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

42.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.

42.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно.

Аль шатны ЗД-тай байгуулах зохицуулалт хийдэлтэй байна.



Дүгнэлт

Дүгнэлт

- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж батлуулснаар Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдэл арилж, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд, орон нутгийн иргэд төдийгүй төрийн байгууллагын түвшинд үүсээд байдаг хүндрэлтэй асуудлууд шийдэгдэнэ. Мөн эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжуудын хийдэл, зөрчил, давхардлыг арилгаснаар ил тод, хариуцлагатай уул уурхайн тогтолцоог олон улсын чиг хандлагад нийцүүлэхэд чухал алхам болох юм.

Багаар ажиллах даалгавар, асуулт, хариулт

1. А компани нь ашигт малтмалын баяжуулах үйлдвэр барихаар холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн байна. Энэ тохиолдолд хэнээс тусгай зөвшөөрөл авах вэ?
2. Танай аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Б компани нь хүдрийн далд уурхайтай. Энэ уурхайн аюулгүй ажиллагаанд баримтлах дүрэм байхгүйгээс компанид төрийн эрх бүхий байгууллагаас шаардлага тавих боломжгүй нөхцөл байдал бий болсон.
 - Аймгийн засаг дарга энэ дүрмийг баталж болох уу? Яагаад?
 - Уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийг хэн батлах вэ?

Багаар ажиллах даалгавар, асуулт, хариулт

1. Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар ашигт малтмалын баяжуулах үйлдвэр ажиллуулахад тусгай зөвшөөрөл **олгодоггүй**. Үйл ажиллагааг шууд явуулна.
2. Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар хүдрийн далд уурхайн дүрмийг батлах эрх олгогдоогүй. Захиргааны ерөнхий хуулийн дагуу заавал эрх олгосон байна.
 - Аймгийн засаг дарга энэ дүрмийг баталж болохгүй. Учир нь эрх олгосон заалт байхгүй.
 - Хэн ч батлахгүй. Учир нь эрх олгосон заалт байхгүй.



Баярлалаа